



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/164/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:              Ж.Өсөхбаяр Утас: 99890393      Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

## **Агуулга**

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Төлбөрийн акт.....	13
4.2 Албан шаардлага .....	13
4.3 Зөвлөмж .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.Аудитын санал дүгнэлт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/102

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

• 005020483

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>88,540,354.05</b>	<b>115,781,786.25</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	66,125.00	462,801.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	66,125.00	462,801.81
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	88,474,229.05	115,318,984.44
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	143,818.22	890,000.04
35130	Эм боох материал	143,818.22	890,000.04
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,330,410.83	114,428,984.40
35410	Бичиг хэргийн материал	3,144,500.00	2,938,100.00
35420	Аж ахуйн материал	27,670,832.80	58,495,240.00
35440	Түлш, шатах тослох материал	515,240.56	00.00
35450	Барилгын засварын материал	13,675,500.00	2,423,199.93
35460	Хүнсний материал	624,472.07	1,199,116.07
35470	Бусад хангамжийн материал	42,699,865.40	49,373,328.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,297,662,730.51</b>	<b>1,295,518,842.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,297,662,730.51	1,295,518,842.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,156,187,730.51	1,154,043,842.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,159,294,845.71	1,158,494,845.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,810,725.71	-84,044,651.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,579,058.00	84,124,057.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,822,685.33	-46,011,269.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,178,127.86	60,738,127.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,586,415.52	-21,301,783.28
39209	Зам, гүүрийн байгууламж	57,500.00	57,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-57,500.00	-57,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	746,509.50	00.00
39217	Ном	609,016.00	2,044,516.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	141,475,000.00	141,475,000.00
39301	Програм хангамж	682,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-682,000.00	-682,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	141,475,000.00	141,475,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,386,203,084.56</b>	<b>1,411,300,628.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>22,499.92</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	22,499.92	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	22,499.92	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	22,499.92	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	22,499.92	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,386,180,584.64</b>	<b>1,411,300,628.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,386,180,584.64	1,411,300,628.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	248,814,143.50	248,814,143.50
51101	Өмч: - төрийн	248,814,143.50	248,814,143.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	971,220,327.71	996,340,371.48
51210	Өмнөх үеийн үр дүн	971,220,327.71	971,220,327.71
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	25,120,043.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,146,113.43	166,146,113.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,386,203,084.56</b>	<b>1,411,300,628.41</b>

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>659,797,800.00</b>	<b>735,971,508.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>16,966,633.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	16,966,633.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	2,275,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	14,691,633.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>659,797,800.00</b>	<b>719,004,875.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	541,581,600.00	561,678,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,581,600.00	561,678,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	41,197,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	41,197,750.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	118,216,200.00	116,129,125.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,216,200.00	116,129,125.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>672,134,033.13</b>	<b>709,304,954.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>672,134,033.13</b>	<b>709,304,954.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	665,831,650.15	689,097,665.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	398,274,446.72	401,818,699.34
210101	Үндсэн цалин	294,770,364.13	343,392,271.70
210102	Нэмэгдэл	78,891,100.00	44,441,633.64
210104	Урамшуулал	24,612,982.59	13,984,794.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,865,635.87	53,255,873.03
210201	Тэтгэврийн даатгал	33,817,035.87	41,000,173.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,012,100.00	3,063,800.00
210203	ҮОМШО-ний даатгал	3,209,700.00	2,451,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	802,500.00	612,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,024,300.00	6,128,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	104,978,060.00	103,232,225.00
210301	Гэрэл, цахилгаан	962,900.00	1,198,913.00
210302	Түлш, халаалт	35,512,728.00	35,236,320.00
210303	Цэвэр, бохир ус	14,502,432.00	12,796,992.00
210304	Байрны түрээс	54,000,000.00	54,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,370,277.43	10,806,913.44
210401	Бичиг хэрэг	1,351,490.00	1,261,500.00
210402	Гээвэр, шатахуун	1,385,000.00	2,513,240.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,201,585.43	895,740.00
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	903,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,962,850.00	6,091,432.80
210408	Бараа материал акталсны зардал	16,565,952.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,843,808.90	25,996,987.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	679,720.90	2,205,318.18
210502	Хоол, хүнс	50,099,288.00	23,791,669.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	64,800.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,701,900.00	16,984,200.07
210604	Урсгал засвар	2,701,900.00	16,984,200.07
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	370,000.00	45,817,390.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	45,584,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	233,250.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,427,521.23	31,185,377.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	805,000.00	1,047,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,622,521.23	30,137,877.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,302,382.98	20,207,288.82
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	11,698,080.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,607,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	3,091,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,938,140.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,938,140.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,664,242.98	8,509,208.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,664,242.98	8,509,208.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-12,336,233.13</b>	<b>26,666,553.27</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	4,983,111.89	1,546,509.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,983,111.89	1,546,509.50
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-4,983,111.89	-1,546,509.50
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-17,319,345.02</b>	<b>25,120,043.77</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>659,797,800.00</b>	<b>719,004,875.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>659,797,800.00</b>	<b>719,004,875.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	541,581,600.00	561,678,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,581,600.00	561,678,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	41,197,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	41,197,750.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	118,216,200.00	116,129,125.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,216,200.00	116,129,125.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>641,681,384.00</b>	<b>691,739,376.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>641,681,384.00</b>	<b>691,739,376.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>635,379,001.02</b>	<b>671,532,087.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	395,751,635.59	396,092,549.18
210101	Үндсэн цалин	292,247,553.00	296,799,200.00
210102	Нэмэгдэл	78,891,100.00	74,812,030.79
210104	Урамшуулал	24,612,982.59	24,481,318.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,151,700.00	59,378,700.00
210201	Тэтгэврийн даатгал	34,103,100.00	43,236,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,012,100.00	4,035,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,700.00	3,228,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	802,500.00	807,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,024,300.00	8,070,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	104,978,060.00	103,232,225.00
210301	Гэрэл, цахилгаан	962,900.00	1,198,913.00
210302	Түлш, халаалт	35,512,728.00	35,236,320.00
210303	Цэвэр, бохир ус	14,502,432.00	12,796,992.00
210304	Байрны түрээс	54,000,000.00	54,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,805,285.43	10,854,440.00
210401	Бичиг хэрэг	1,002,000.00	787,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,998,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,261,585.43	895,740.00
210404	Ном, хэвлэл	585,000.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	903,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,153,300.00	7,128,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	57,248,920.00	51,161,753.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,630,000.00	9,241,500.00
210502	Хоол, хүнс	47,872,120.00	24,366,313.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,746,800.00	17,553,940.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,486,400.00	7,709,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,521,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,965,400.00	7,709,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	887,000.00	33,487,220.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	637,000.00	33,253,970.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	233,250.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,070,000.00	9,615,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,069,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,070,000.00	2,545,800.00

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,302,382.98</b>	<b>20,207,288.82</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	11,698,080.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,607,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	3,091,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,938,140.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,938,140.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,664,242.98	8,509,208.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,664,242.98	8,509,208.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>18,116,416.00</b>	<b>27,265,499.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>18,116,416.00</b>	<b>27,265,499.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,116,416.00</b>	<b>27,265,499.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	18,116,416.00	27,265,499.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,116,416.00	27,265,499.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-18,116,416.00</b>	<b>-27,265,499.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	00.00	988,539,672.73	1,237,353,816.23	
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>248,814,143.50</b>	<b>00.00</b>	<b>988,539,672.73</b>	1,237,353,816.23	
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,181,194.30	17,181,194.30	
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>248,814,143.50</b>	<b>166,146,113.43</b>	<b>971,220,327.71</b>	1,386,180,584.64	
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>248,814,143.50</b>	<b>166,146,113.43</b>	<b>971,220,327.71</b>	1,386,180,584.64	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>248,814,143.50</b>	<b>166,146,113.43</b>	<b>971,220,327.71</b>	1,386,180,584.64	
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,120,043.77	25,120,043.77	
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>248,814,143.50</b>	<b>166,146,113.43</b>	<b>996,340,371.48</b>	1,411,300,628.41	

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	683,186,500.00	669,297,916.18	13,888,583.82	98.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	683,186,500.00	669,297,916.18	13,888,583.82	98.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	680,063,800.00	666,206,916.18	13,856,883.82	98.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	402,485,100.00	396,092,549.18	6,392,550.82	98.4
210101	Үндсэн цалин	296,799,200.00	296,799,200.00	00.00	100.0
210102	Нэмэгдэл	79,349,800.00	74,812,030.79	4,537,769.21	94.3
210104	Урамшуулал	26,336,100.00	24,481,318.39	1,854,781.61	93.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,378,700.00	59,378,700.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	43,236,800.00	43,236,800.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,035,500.00	4,035,500.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,228,400.00	3,228,400.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	807,100.00	807,100.00	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,070,900.00	8,070,900.00	00.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	108,608,500.00	103,232,225.00	5,376,275.00	95.0
210301	Гэрэл, цахилгаан	6,517,700.00	1,198,913.00	5,318,787.00	18.4
210302	Түлш, халаалт	35,228,800.00	35,236,320.00	-7,520.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	12,862,000.00	12,796,992.00	65,008.00	99.5
210304	Байрны түрээс	54,000,000.00	54,000,000.00	00.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,154,000.00	17,151,940.00	2,060.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,120,900.00	787,500.00	333,400.00	70.3
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,998,000.00	2,000.00	99.9

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	895,740.00	591,060.00	60.2
210404	Ном, хэвлэл	122,700.00	1,062,500.00	-939,800.00	865.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,423,600.00	12,408,200.00	15,400.00	99.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>53,193,400.00</b>	<b>51,161,753.00</b>	<b>2,031,647.00</b>	<b>96.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,249,600.00	9,241,500.00	8,100.00	99.9
210502	Хоол, хүнс	26,326,500.00	24,366,313.00	1,960,187.00	92.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,617,300.00	17,553,940.00	63,360.00	99.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,276,400.00</b>	<b>28,259,899.00</b>	<b>16,501.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	12,989,999.00	10,001.00	99.9
210604	Урсгал засвар	15,276,400.00	15,269,900.00	6,500.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>903,900.00</b>	<b>896,550.00</b>	<b>7,350.00</b>	<b>99.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	663,900.00	663,300.00	600.00	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	233,250.00	6,750.00	97.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10063800.00</b>	<b>10033300.00</b>	<b>30,500.00</b>	<b>99.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,100,000.00	7,069,500.00	30,500.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,963,800.00	2,963,800.00	00.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3122700.00</b>	<b>3091000.00</b>	<b>31,700.00</b>	<b>99.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,122,700.00</b>	<b>3,091,000.00</b>	<b>31,700.00</b>	<b>99.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,122,700.00	3,091,000.00	31,700.00	99.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>683,186,500.00</b>	<b>669,297,916.18</b>	<b>13,888,583.82</b>	<b>98.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>561,678,000.00</b>	<b>553,168,791.18</b>	<b>8,509,208.82</b>	<b>98.5</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	561,678,000.00	553,168,791.18	8,509,208.82	98.5
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>121,508,500.00</b>	<b>116,129,125.00</b>	<b>5,379,375.00</b>	<b>95.6</b>
132001	Орон нутгийн төсвөөс	121,508,500.00	116,129,125.00	5,379,375.00	95.6
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>38.00</b>	<b>38.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	00.00	100.0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>326.00</b>	<b>231.00</b>	<b>95.00</b>	<b>70.9</b>
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>326.00</b>	<b>231.00</b>	<b>95.00</b>	<b>70.9</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	326.00	231.00	95.00	70.9
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>38.00</b>	<b>38.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	22.00	22.00	00.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16.00	16.00	00.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр /	
			Гүйцэтгэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>41,197,750.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>41,197,750.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		32,590,670.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		32,590,670.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		32,590,670.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	8607080.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		8,607,080.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,607,080.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>41,197,750.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>41,197,750.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		41,197,750.00	
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг захирал Л.Аюурзана, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Амаржаргал нар зурсан байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багш бүр хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, сурах үйлийн таатай орчныг бүрдүүлэн, агуулгын хоцрогдлыг арилгаж, хичээлийн цахим сантай болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 672,134.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,082.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,057.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 10,639.6 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,097.5 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	88,540.4	115,781.8	27,241.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	66.1	462.8	396.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	88,474.2	115,319.0	26,844.8
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,297,662.7	1,295,518.8	(2,143.9)
Үндсэн хөрөнгө	1,419,622.1	1,447,616.0	27,994.0
Хуримтлагдсан элэгдэл	(121,959.3)	(152,097.2)	(30,137.9)
<b>Нийт хөрөнгө</b>	1,386,203.1	1,411,300.6	25,097.5
Өр төлбөр	22.5	-	(22.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,386,180.6	1,411,300.6	25,120.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,386,203.1	1,411,300.6	25,097.5

Авлагын дансны үлдэгдэл 396.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онд ажиллагсадтай холбоотой 66.1 мянган төгрөгийн утасны төлбөрийн авлага үүссэнийг суутган тооцож барагдуулсан ба тайлант хувь хүний орлогын татварын 462.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115,319.0 мянган төгрөг болж 26,844.8 мянган төсвийн хөрөнгөөр худалдан авсан 31,420.4 мянган төгрөгийн материалыг аж ахуйн материал дансанд бүртгэж зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,447,616.0 мянган төгрөг болж 27,994.0 мянган төгрөгөөр өссөн нь 27,265.5 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2,275.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн орлого авч бүртгэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар тогтоолоор 1,546.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,411,300.6 мянган төгрөг болж 25,097.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 25,097.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх зардлыг 772,181.2 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлыг 148,404.0 мянга, нийт зарлагыг 920,585.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 187,890.8 мянган төгрөгөөр бууруулж 732,694.4 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг улсын төсвийн 683,186.5 мянган төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 561,678.0 мянга, орон нутгийн төсвөөс 116,129.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 669,297.9 мянган төгрөгийг зарцуулж 8,509.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 669,297.6 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлыг 6,392.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,376.3 мянга, нормативд зардлыг 2,031.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 6 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 709,304.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 37,170.9 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,033,954.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 9 дүгээр сард таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, худалдан авалттай холбоотой 81,857.5 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### **Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 732,694.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 49,507.9 мянган төгрөг хасаж баталснаас 561,678.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 121,508.5 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан ба гүйцэтгэлээр 669,297.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 8.6 хувийн хэмнэлт гаргасан байна.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 123,365.1 мянган төгрөгөөр, тодотголоор 108,608.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр

103,232.2 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 20,132.9 мянган төгрөг буюу 16.3 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 1,120.9 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 787.5 мянган төгрөг зарцуулж 42.3 хувийн хэмнэлт гаргасан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 60,112.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 652.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 59,460.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй**

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 10,665.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 652.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 139.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 9,873.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүллээ.

### **4.1 Төлбөрийн акт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үдийн цайны зардлын нормативыг хэтрүүлэн илүү зарцуулсан 652.4 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон ч хүнсний зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудаар буцаан 652.4 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **4.2 Албан шаардлага**

1. Ажиллагсдын цалинг 2021 оны 01, 05 дугаар саруудад Нийгмийн даатгалын хэлтэст 139.8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 139.8 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### **4.3 Зөвлөмж**

Тус байгууллагын 2021 оны төсвийг 732,694.4 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 49,507.9 мянган төгрөгөөр хасаж баталснаас 561,678.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 121,508.5 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан ба гүйцэтгэлээр 669,297.9 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 8.6 хувийн хэмнэлт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж,

зардлыг гаргахгүй байх зэргээр төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс 163 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 9-р сард цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 81857.5 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Тус байгууллагын нярав нь хүнсний материалаас бусад аж ахуйн материалын няравын тайланг сар бүр гаргаагүй улирал, хагас бүтэн жилээр гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Тасалбар болголт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Няравын тайланг анхан шатны баримтад үндэслэн гаргаж, түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэг	5	10665.2	-	-	1	652.4	1	139.8	3	9873.0

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_